



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А04

Хараат

Сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 2 дугаар сарын 22-ний өдрийн 65 дугаар тогтоолын 2, 3 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн өмчийг аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, ашиглалтад хяналт тавих, эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах зэргээр эд хөрөнгийн зохицуулалт, орон нутгийн өмч хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг судалж зөвлөмж, дүгнэлт гаргаж ажиллах үүрэг бүхий сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга: -Засаг даргын орлогч

- Төрийн сангийн мэргэжилтэн
- Эрүүл мэндийн төвийн дарга
- Нийгмийн бодлогын ажилтан
- Хүүхдийн цэцэрлэгийн туслах багш

2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг мөрдлөг болгон сум орон нутагт хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдөрт багтаан батлуулж хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлийн дарга (Н.Батгэрэл)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/39 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  А.ЭРДЭНЭСАЙХАН



4873000006